



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/200

Хархорин сум

Эзэмшил газрын хэлбэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.6 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Орхон хороолол 37 тоотод байрлалтай 2250м² газрыг Төрийн банк нь банк санхүүгийн байгууллагын зориулалтаар эзэмшиж байгаа тус газрыг тухайн зориулалтаар хэмжээ байршил өөрчлөхгүйгээр хэлбэрийг нь өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмигч "Төрийн банк"-д газар эзэмших эрхийн эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (Төрийн банк)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын газар эзэмшүүлэх тухай 2020 оны А/167 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100300